



THE WORLD OF THE LOTUS SUTRA

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Даган баясалцсан буяны ач үрийг үзүүлсэн хэмээх 18-р бүлэг

Энэ бүлэгт сургаалыг сонсоод даган баясах анхны сэтгэлийн ач буян ямар болохыг өгүүлнэ. Учир нь сургаалыг сонсоод “Ямар гайхалтай, сайхан юм бэ” хэмээн чин сэтгэлээсээ баярлах тэрхүү сэтгэл хөдлөл нь сүсэг бишрэлийн үндсэн чухал хүчин зүйл болдог юм.

Майдар бодисадва Шагжамүни буддагаас асуув. “Цагаан Лянхуа Сударын сургаалыг сонсоод баярлах сэтгэл төрөх аваас тэр буяны ач ямар байх вэ?”

Шагжамүни будда ийнхүү хариулав. “Сургаалыг сонсоод даган баясаж, сонссон сургаалаа тэр чигээр нь өөрийнхөө чадах чинээгээр хэн нэгэн хүнд дамжуулсан гэж бодъё. Түүнийг сонссон хүмүүс ч мөн адил даган баясаж, сургаалыг дахин өөр хүнд дамжуулсан гэе. Ийнхүү сургаал нэг хүнээс нөгөөд дамжин, 50 дамжсан гэж бодъё. 50 дахь хүнд ч мөн адил даган баясах сэтгэл төрсөн гэж үзвээс, тэр хүний эдлэх буян хүртэл туйлын их болой.”

Энэхүү буяны ач ямар болох талаар Шагжамүни будда ийнхүү өгүүлнэ. “Нэгэн хүн 80 жилийн турш хамаг амьтан бүхнийг аз жаргалтай болгохын төлөө тэдний хүссэн зүйлийг бүгдийг өгсөн гэж бодъё. Дээр нь төөрөгдлөөсөө ангижирсан сэтгэлийн түвшинд хүргэх номын өглөг хийсэн гэе. Тэр агуу өглөгтний олж авах буяны ачийг саяны өгүүлсэн 50 дахь хүний баясах сэтгэлийн үр дүнд олж авах буяны ачтай харьцуулах юм бол 100-ны нэг, 1000-ны нэг, эсвэл зуун мянган дүнчүүр(10¹⁷)-ийн нэгд ч хүрэхгүй. Бүр тоогоор хэмжихийн аргагүй ч гэж хэлж болно. 50 хүн дамжиж хүрсэн ч гэсэн Цагаан Лянхуа Сударыг даган баясах буяны ач ийм агуу билээ. Тиймээс сургаалыг сонсоод баясах сэтгэл төрсөн хамгийн эхний хүний олж эдлэх буян юутай ч харьцуулахын аргагүй хэмжээлшгүй хязгааргүй болой.”

Шагжамүни будда сургаалаа үргэлжлүүлэн айлдана. “Нэгэн хүн Цагаан Лянхуа Сударыг

сонсъя хэмээн номын өргөөнд очиж, хэсэгхэн зуур сургаал сонслоо гэж бодъё. Тэр хүн энэхүү буянт сэтгэлийн үр дүнд сайн төрөлд дахин төрж, гайхамшигт хөлгөнд сууж, тэнгэрийн орон дахь ордонд залрах болой. Өөр нэгэн сургаал сонсон сууж буй хүн сүүлд ирсэн хүнийг хараад, энд суугаад сургаал сонсогтун хэмээн урих юмуу суудлаа хуваан сууж хэмээн бодъё. Тэгвэл тэр хүн Индра болон Брахма тэнгэрийн оронд очиж, эсвэл Хүрдэн орчуудагч хаантай зэргэцэн суух болой. Цашилбал, нэгэн хүн хэн нэгнийг “Цагаан Лянхуа Судар хэмээх сургаалыг сонсохоор хамтдаа явцгаая” гэж уриалан, урисан хүн нь хэсэгхэн зуур сургаалыг сонссон гэж бодъё. Тэгвэл тэр урисан хүн нь ийнхүү буян үйлдсэний ачаар Тарнийн хүчит бодисадвагийн дэргэд дахин мэндэлж, жинхэнэ үнэний сургаалыг ойлгох хурц соргог ухаантай, билиг оюуныг цогцлоосон хүмүүн болох болой. Түүнчлэн дараа төрөлдөө ч буянт төрхийг цогцлоох болой. Үүгээр ч барахгүй хэдэн удаа дахин төрсөн ч бурханы дэргэд мэндэлж, сургаал сонсож, сургаалыг хүлээн авч тогтоох болой. Ганцхан хүнд сургаалыг сонсгох буяны ач ийм болно. Тэгвэл сургаалыг чин сэтгэлээсээ сонсож, бясалган уншиж, хамаг олны төлөө янз бүрийн аргаар түгээн дэлгэрүүлж, тэдгээр хүмүүс нь сургаалыг заасных нь дагуу хэрэгжүүлсэн гэвэл, тэр буяны ач ямар болохыг хэмжихийн аргагүй билээ.”



Зовлон баяр баясал болж хувирах нь

Ус хүчилтөрөгч ба устөрөгч хоёроос бүрддэг гэдгийг та бүхэн мэдэх билээ. Тэгвэл хүний бие юунаас бүрддэг юм бол?

Шинжлэх ухааны хариултыг мэргэжлийн хүмүүст нь даатгая. Миний хувьд бидний бие махбодь бусад олон амьтан, ургамлын амийг хүнс тэжээл болгон хэрэглэхээс авахуулаад маш олон зүйлийн ачаар оршин тогтнож байдаг гэдэг нь зөв хариулт болов уу. Өөрөөр хэлбэл, бид тоолж баршгүй олон зүйл, тэдгээр хүчин зүйл болгоны ачаар амьдарч байдаг бөгөөд энэ нь эсрэгээр бид өөрсдөө ч гэсэн бусдыг амьдруулах нэгэн хүчин зүйл болж байдаг гэж хэлж болох биз ээ.

Гэтэл бид үүнийг умартаж, ямар нэг зүйлд сэтгэл ханахгүй гомдоллон, бусдад атаархаж байдаг. Мөн өөрчлөлт хувиралтыг мөнх бус хуулийн үүднээс аваад үзвэл мэдээжийн зүйл байхад, тэр нь бидэнд тааламжгүй зүйл байх юм бол хүлээн авч чадалгүй, ихэнх тохиолдолд зовлон хэмээн боддог.

Буддизмд “бүх бодит үзэгдэл хоосон” хэмээх сургаал байдаг. Өөрөөр хэлбэл юмс үзэгдэлд сайн, муу гэж байдаггүй, нойл буюу хоосон чанартай байдаг. Хэцүү, гаслантай, зовлонтой гэж бодох сэтгэлээ нойллож, хов хоосон болгоод, нүдний өмнө тулгараад байгаа үзэгдлийг байгаагаар нь хараад үзэх юм бол илүү уужим сэтгэлээр хүлээн авч чадах болов уу. Жишээлбэл, зовлон нь баяр баясал, амьдрах хүслэн болон хувирч, гаслан



зовлон нь сэтгэлийг хөгжүүлэх ба уур хилэнд хүртэл “баярлалаа” гэж хэлж чаддаг болно. Үүний эх үндэс нь шүтэн барилдлагын хууль, мөнх бусын хууль, хоосон чанарын хууль зэрэг Жинхэнэ Үнэнийг ухамсарлахад оршино. Тиймээс Жинхэнэ Үнэний сургаалыг суралцсанаар аз жаргалыг илүү ихээр мэдрэх юм.

Оны эцэс ойртож өнгөрсөн жилээ эргэн харж дүгнэх цаг боллоо. Ийм үед бид нэгэн хэвийн, баригдмал үзэл бодлоосоо салж, аль болох юмыг өргөнөөр харж, “таны ач буянаар” гэсэн талархсан сэтгэлийн үрийг тарьж, шинэ оноо угтвал ямар вэ?

Эдогийн үеийн дуучин Тачибана Акеми “баяр хөөр” гэсэн үгээр эхэлсэн олон дуу үлдээсэн билээ.

“Баяр хөөр гэдэг өглөө босоод цэцэг дэлгэрсэн байхыг олж харах явдал”, “баяр хөөр гэдэг намар будаагаа хураачихаад сэтгэл амар суух явдал.” Энэ дуу мэт өдөр тутам тохиолдох энгийн зүйлд баярлан талархаж, тэндээс аз жаргалыг мэдэрдэг болох юм бол үглэж, гомдолох нь аяндаа багасаж ирнэ. Би ч гэсэн бурханы сургаалыг сурснаар үргэлж үглэж, дургүйцэж байдаг байсан өөрийгөө засаж, “харах өнцгөө өөрчлөх юм бол талархмаар сайхан зүйл хаа сайгүй байдаг юм байна” гэдгийг ойлгосон маань хамгийн сайн хэрэг гэж боддог юм.

Ийнхүү “талархмаар”, “таны ач буянаар” гэж бодсоноор энэрэнгүй сэтгэл төрж, уян зөөлөн, халуун дулаан үг сэтгэлээс гарах

болно. Яагаад гэвэл Жинхэнэ Үнэний сургаалд суралцсанаар “бүгд нэгэн амьтай” гэдгийг ухамсарлаж, бусдыг энэрэх сэтгэл өөрийн эрхгүй төрнө. «Хайрлавал хайрлуулна» гэсэн үгийн дагуу ийнхүү бусдын төлөө хийсэн үйлийн хариу заавал өөрт эргэж ирдэг билээ.

“Баярлалаа” хэмээн хэлж, талархсан сэтгэлээ үйл хөдлөлөөрөө илэрхийлснээр бусдыг баярлуулж, улмаар тухайн хүн ч танд талархах болно. Ийнхүү харилцан бие биенээ ойлгож, халуун дулаан уур амьсгал бүрдсэнээр бид баяр хөөр, амьдрах эрч хүчийг мэдэрдэг. Нэг үгээр хэлбэл бурханы сургаалыг бусдад дамжуулах үйл нь аз жаргалтай амьдралыг бий болгох агуу хүч болдог юм. Яагаад гэвэл бурханы сургаал бол ямар ч гутарч гунисан хүний сэтгэлд “талархал” хэмээх өөдрөг гэгээлэг гэрлийг тусгадаг юм.

Юуны өмнө хамгийн ойр дотны хүмүүстэй “таны ач буянаар” хэмээн талархахаас эхэлцгээе. Ач зээ нар маань эрүүл саруул өсөж том болж байгаа нь “таны ач буян”. Ингэж бодож чаддаг болсон маань нь ч “таны ач буян”. Ийнхүү өдөр тутам тохиолдох жижигхээн зүйлд талархаж, баяр баясал, аз жаргалыг мэдрэх нь хүний амьдралын аз жаргалын түлхүүр болдог билээ.

“Косэй” 2012 оны 12 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

Рисшо Косей Кай Нийгэмлэгийн Ирээдүйн Ерөнхийлөгч
Нивано Коошо

Арвич хямгач охид

- “Та охиндоо нэг дээс аваад өгөхгүй юу? 100 йений дэлгүүрт ч зардаг шүү дээ”

- “Юу? Дээс үү?”

Анх удаагийн эцэг эх, багшийн ярилцлага дээр ийм зүйл сонсоод алмайрч билээ. Нэгдүгээр ангид сурдаг хоёр дахь охины маань хичээлийн 1-р улирал дуусч, зуны амралт эхлэх гэж байв.

- “Мэдээж хэрэг хэрэгтэй бол авалгүй яахав” гэж би хариулсан юм.

Багшийн ярьж байгаагаар бол хоёр дахь охин маань эгчийнхээ дээсийг 1-р улиралын үеэр хамт хэрэглэсэн байв. 1-р анги ба 3-р ангийн дээс хэрэглэх биеийн тамирын хичээл нь зөрж байсан тул дүү нь хэрэгтэй үедээ эгч дээрээ ирж дээсийг нь зээлэн авдаг байсан байв.

Гэтэл нэг өдөр цагийн хуваарь нь өөрчлөгдчихжээ. Дүү нь эгчийнхээ дээсийг зээлэх гэж очтол 3-р ангийнхан дээсээр тоглож байв. Бага охин маань яах ч аргагүй багш дээрээ очиж учраа тайлбарлан, хоёрын хоёр дээс авах нь хайран учраас эгчтэйгээ нэг дээсээ хамт хэрэглэхийг шийдсэн гэдгээ ч хэлсэн байлаа.

Би тэр үед бага охиныхоо гэрийн даалгавар байтугай хичээлийнх нь цагийн хуваарийг ч сайн харж үздэггүй байсан юм.

Анхны хүүхэд болох том охин, дөнгөж цэцэрлэгт орсон гурав дахь буюу хамгийн бага охиндоо л анхаарлаа төвлөрүүлж, хоёр дахь охин маань ангидаа ганцаархнаа дээсгүй байсныг өдий болтод анзаараагүй байна гэдэг. Хоёр сарын дараа дөрвөн хүүхдийн эх болох гэж байж гэж бодохоор, багш нь юу гэж бодсон бол хэмээн ичих шиг болж, хоёр дахь охиноо ч өрөвдсөн юм.

Тэгээд гэртээ харингуутаа охиддоо “Та нарт дээс авч өгье” гэхэд тэр



Нивано Коошо

Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн. Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагтай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн дараагийн ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

хоёр хоёулаа нэгэн зэрэг “Өө, хэрэггүй ээ. Биеийн тамирын цаг давхацсан нь зөвхөн тэр өдөр л байсан юм. Авч яах юм, хайран шүү дээ” гэдэг байна.

Охин маань сургуулийн дүрэмт хувцас, 1-р ангидаа хэрэглэсэн аман хуур хөгжим, ханзны дэвтэр гээд бүх зүйлсээ эгчээсээ өвлөн авдаг байсан юм.

Цэцэрлэгт орсон хамгийн бага охин маань ч гэсэн эгч нарынхаа хуучин цүнх, хувцасыг хэрэглэж байв. Том охин маань ч дүү нарынхаа төлөө ямар ч юмаа цэвэрхэн гоё хэрэглэхийг хичээнэ. Дүү нар нь ч гомдол хэлэлгүй баяртайгаар эгчийнхээ хуучин зүйлүүдийг хэрэглэдэг байв.

Охидууд маань ийнхүү хайран учраас хоёрын хоёр дээс хэрэггүй гэсэн юм. Охидуудаа бага зэрэг өрөвдсөн ч, ийм багаасаа ямар айхтар, тооцоотой хүүхдүүд вэ гэж бодохоор нэг л итгэмээргүй санагдаж байв. Тэгээд тэр хоёроос гуйхаар шийдэв.

- “Ээж нь охиддоо баярлалаа. Гэхдээ ээж нь та хоёрт хоёуланд чинь нэг нэг дээс авч өгмөөр байна, болох уу?”

- “За, тэгвэл тэгье” гэж тэр хоёр хариулав. Бага охин маань “Ямар өнгө дээр вэ?” хэмээн баяртайгаар бодлогширно. Эгч нь ч бас баярлаж байв.

- “Би лав 100 йений дэлгүүрээс л авна” гэж бага охин маань хэлэв.

Биеэ даасан, айхтар арвич хямгач охин ч гэсэн шинэ юм сайхан санагдах нь аргагүй шүү дээ.

Маргааш нь бүгдээрээ хамт дээс авахаар 100 йений дэлгүүр явав. Нэмж хэлэхэд автобусны үнэ 420 йен болсон юм даа.

“Бурхан багшийн дуу хоолой”

Бразил нийгэмлэг
Сасаки Ринюү

2012.10.06 РКК Бразил нийгэмлэг

Үүсгэн байгуулагчийн бурхан болсон өдрийн ёслолын үйл ажиллагаан дээр тавигдсан илтгэл

Бразил дахь нийгэмлэг дээр хүлээн авсан хамгийн анхны үүрэг бол зураг авах үүрэг байв. 2004 оны 6 сарын 6-ны нийгэмлэг дээр бурхан тахих ёслолын үйл ажиллагааны үеэр байв. Бурхан багшийн дүрийг залах үеийн нөхцөл байдлыг зургийн хальснаа буулгах зуур миний сэтгэл маш их хөдөлж байсныг санаж байна. Бурханаа хүлээн авч буй гишүүдийн хувьд энэ үйл явдал хичнээн чухал болохыг би тэдний үйл хөдлөлөөс харж байв. Ёслолын үйл ажиллагаа дууссаны дараа тухайн үед үерхэж байсан нийгэмлэгийн сургаал түгээх туслах ажилтан Мацүмүра Хиромид хандан “хэзээ нэгэн цагт би ч гэсэн бурхан залж авмаар байна” гэж хэлж байж билээ.

Хэдэн жилийн дараа би Хиромитой гэрлэсэн юм. Нагашима тэргүүнээс хэд хэдэн удаа “ариун ордон уруу явж бурханаа залж ирвэл ямар вэ” хэмээн зөвлөсөн боловч тэр болгонд би татгалзсан хариу өгдөг байв.

Бурхан залуулах хүсэл байсан боловч Их Ариун Ордон хүртэл явах сонирхол байхгүй байсан юм.

РКК-тай холбогдсоны ачаар миний эргэн тойронд янз бүрийн талархмаар үйл явдлууд тохиох болов. Бурхан багшийн сургаалыг сонирхон суралцах болж, мөн өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээх болов. Улмаар бурханы авралаар гэр бүл болон хамаатнуудтайгаа илүү сайн харилцаатай болж, ажлын захиалга нэмэгдэж, түүнчлэн хандив өргөх явцад орлого маань ч нэмэгдэв.



Бразил нийгэмлэг, Үүсгэн байгуулагчийн бурхан болсон өдрийн ёслол

Түүнчлэн 3 хүүхэд хайрласан нь бидний амьдралд гэрэл гэгээ нэмсэн юм.

Энэ жил ч гэсэн тэргүүн бурхан залуулах тухай дахин зөвлөв. Хүүхдүүдээ асрах болон ажлынхаа талаар бодохоор энэ удаа ч гэсэн татгалзсан нь дээр болов уу гэж дотроо бодов. Гэвч энэ удаа Хиромигийн царай урьдынхаасаа нэг л ондоо байв. “Яадаг ч байсан энэ удаа бурханаа залмаар байна” гэсэн хүсэл царайнаас нь тодорч байсан юм.

Би ч гэсэн эхнэрийнхээ яриаг сонсоод, энэ удаа бурхан залуулахад хамгийн тохиромжтой үе байж магадгүй хэмээн бодож, бурханаа залуулахаар шийдэв. Үүнд эхнэр маань хамгийн ихээр баярлав. Тэр өдрөөс эхлэн эхнэр маань орой бүр залуулах бурханыхаа хэлбэр, хэмжээ, өнгөний талаар ярьж, надаас илүү догдолж байв. Болдогсон бол эхнэртэйгээ цуг онгоцонд суугаад Ариун ордон уруу явмаар санагддаг байв.

Бэлтгэл хангагдаж, Япон явах өдөр ирэв. Тэр үед Бразил нийгэмлэгийн тэргүүн шинэ салбарт бурхан залахаар, ниймийн хэрэг эрхлэх хэлтсийн ахлагч Кишихидэо гэртээ бурхан залахаар надтай хамт явсан юм. Ийнхүү гурван эрэгтэйн богино боловч урт аялал эхлэв. Онгоцны урт аялал үнэндээ миний хувьд хамгийн хэцүү даваа байв. Учир нь би онгоцон дотор унтаж чаддаггүй хүн юм. Дээрээс нь миний суусан суудлын дэлгэцний дуу сонсогдохгүй байв. Ингээд би Сан Паулогоос Америкийн Даллас хүртэл дуугүй кино үзэхэд хүрэв. Далласаас сольж суусан онгоц 3 цаг хоцорсны дээр, дэлгэцийн суваг солигддоггүй суудал надад таарав. Ингээд би Нарита онгоцны буудал ортол аргагүйн эрхэнд онгоцны доторхыг ажиглаж, онцгой үед анхаарах зүйлсийг унших зэргээр цагийг өнгөрөөв. Харин энэ үер Тэргүүн болон нийтийн хэрэг эрхлэх хэлтсийн ахлагч Киши нар тааламжтай нь аргагүй унтаж байхыг хараад өөрийн эрхгүй атаархах сэтгэл төрж билээ.

Онгоцны аялал урт тул ядарна гэдгээ мэдэж байсан ч, бодож байснаас илүү ихээр ядрав. 4 өдрийн хөтөлбөртэй байсан тул онгоцны ядаргаа тайлагдаж амжаагүй байхад буцах шаардлагатай байв. Гэвч гэртээ бурхан залж авах хүндтэй үйл явдлын талаар бодохоор онгоцоор зорчиход тулгарсан бэрхшээлүүд юу ч биш

санагдаж, дахин нэг өдөр онгоцоор явсан ч яахав гэж бодогдов.

Бурхан залах өдөр 5 сарын 13-ны “Ээж нарын баяр”-ын өдөртэй давхцав. 6 барамидын гүүрээр Ариун ордон уруу чиглэн алхах зуур зүрх маань хүчтэй цохилохыг мэдрэв. Яг хуримаа хийсэн өдрийх шиг сэтгэл хөөрч байсан юм.

Миний суусан суудал бурхан багшийн чанх урдаас харсан суудал байв. Бурхан багш над уруу харан “хүлээж байсан шүү” гэж хэлэх шиг санагдав. Доошоо хартал том гэгч Лянхуа цэцэгний дүрсэн дотор жижиг алтан өнгийн цагираг харагдав. Тэрхүү дүрс ариун ордоны төв цэг бөгөөд надад бэлдсэн суудал яг төвд нь байрлаж байв. Тэр үед РКК-н Ерөнхийлөгчөөс хүртсэн Ринюү хэмээх бурханы нэрээ санав. РИН гэдэг нь Англи хэлний “цагираг, тойрог” гэсэн утгатай, ЮУ нь япон хэлний “байх, орших” гэсэн утгатай үг юм. Нийлээд “эв нэгдэлтэй тойрог дотор сургаалыг айлдах хүмүүстэй хамт байна” гэсэн утгатай үг юм.

Их Ариун Ордны тавцан уруу гарж байгаагүй тул бурханаа хүлээн авахаар тавцан дээр гарахдаа боломжийг ашиглан гол шүтээн болон бурханы эд хэрэглэлийг сайн хараад авья гэж бодов. Гэвч шатаар өгсөх үед зүрх хүчтэй цохилж, алдаа гаргадаггүй юм шүү гэж залбирч байтал нэг мэдэхэд шатаар бууж байв. Бурхан багшийн дүрийг сайн харах нь битгий хэл гэртээ залах бурханаа хэнээс хүлээж авсанаа ч санахгүй байв. Холливудын од Оскарын шагнал авсны дараах шиг олон хүний халуун алга ташилт, адислалын дунд суудалдаа эргэн ирэв. Олноос хүртсэн тэрхүү адислал хэлбэр төдий зүйл байсан гэж бодохгүй байна. Гэртээ бурхан залж байгаад чин сэтгэлээсээ баярласны илэрхийлэл байсан болов уу. “Нүдэнд харагдахгүй боловч хүн бүрт бурханлиг чанар байдаг” хэмээх үгийг тэр үед би санав. Бурхан багшийн дүр яг л толь шиг, бид судар номоо хурах үед бидний бурханлиг чанарыг тусгаж харуулдаг гэж би боддог юм.

Бурхан залах ёслолын үйл ажиллагаа дууссаны дараа бид ОУ-ын хэлтсийн дарга Мизүтани болон дэд дарга Хагивара нартай ярилцав. Хэлтсийн дарга Мизүтани Цагаан Лянхуа судрын “Номыг даатгасан нь хэмээгч 22-р бүлэг” -ийн талаар айлдав.

“Хутагт Шагжамүни алгуурхан суудлаасаа босон зогсоод их рид хувилгааныг үзүүлэв. Баруун мутраараа тэнд орших тоолж барамгүй олон бодисадва нарын толгойг илээд дараах үгийг айлдав. Би бээр зуун мянган наяд галав хэмээх урт удаан хугацааны туршид санаанд багтамгүй олон бэрх давааг даван, хүрэхэд бэрх бурханы гэгээрэлд хүрсэн бөлгөө. Тэрхүү эрхэм

гэгээрлийг хойч үеийн хүмүүст дамжуулах чухал үүргийг та нарт даатгахыг хүснэм. Та бүгд нэгэн сэтгэлээр сургаалыг айлдан дэлгэрүүлж, олон нүгүүдэд тус хүргэхтүн.

”Баруун гараа дээш өргөн зогсож буй Ариун ордны бурхан багшийн дүр үрүү харахад бидэнд хандан “ Олон хүнд сургаалыг түгээж, сургаалын зам мөрөөр алхацгаая” хэмээн даатгаж буй мэт санагдав.

Бурхан залахын өмнөх өдөр хэлтсийн дэд дарга Хагивара “гэртээ бурхан залахаар амьдрал өөрчлөгддөг юм” хэмээн хэлээд бурхан залсны дараахан машинаа мөргүүлсэн талаар ярьсан юм. Харин миний хувьд хөргөгч, цахилгаан пийшин, машины тормоз, дугуй зэрэгт асуудал үүссэн юм. Би энэ бүх асуудлыг “ердөө л азгүй тохиолдол байлаа” хэмээн хүлээж аваагүй. Машины засвар гэхэд том асуудал бололгүй шийдэгдсэнийг бурханы аврал хэмээн бодож байна. Харин гэр ахуйн цахилгаан барааны хувьд ажлын захиалга нэмэгдсэн тул шинэ загварынхаар солив. Бурханы сургаалтай учирсны ачаар амьдралыг харах өнцөг маань өмнөхөөсөө өөрчлөгдсөн. Азгүй тохиолдол шиг санагдах зүйлийг ч сургаалын ачаар талархан хүлээж авдаг болсон.

Гэртээ бурхан залж авснаар тохиолдуулан хойшид олон хүний аз жаргалын төлөө сургаал түгээнэ хэмээн бодож байна.

Хойшид бусдын төлөө хичээх болно гэдгээ бурхан багш, Үүсгэн байгуулагч, РКК-ийн Ерөнхийлөгчийн өмнө тангараглаж байна.



Сасаки Ринюү илтгэл тавьж байгаа нь



Shanzai сэтгүүлд гишүүд бодит амьдрал дээр бурхан багшийн сургаалыг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай нийтэлж байна.

Та ч гэсэн өөрийн туршлагаа дэлхийн олон орны гишүүдтэй хуваалцахгүй биз?

shanzai

Хатуу зоримог сэтгэл ба уян зөөлөн сэтгэл



Өндөр барилгууд зөвхөн баг бөх байх хангалттай биш. Газар хөдлөлт, хуй салхи зэргийн чичирхийлэлтийн хэмжээг тодорхой хэмжээгээр тооцоолон барихгүй бол болохгүй.

Нисэх онгоцны далавчийг ч гэсэн баг бөх байх ёстой гээд жоохон ч тахийлгалгүйгээр хийх юм бол эсрэгээр хугараад уначихдаг бололтой. Онгоц хатуу ширүүн агаарын урсгалд орох үед “Зүгээр байгаа даа” гэмээр онгоцны далавч дээш доош сажлан сэтгэл сэрвэгнүүлдэг ч, харин ч энэхүү уян зөөлөн чанар нь чухал байдаг байна.

Бурханы үйлд шамдан суралцах ч гэсэн үүнтэй адил. Өнөөдрийг эцсийн өдөр мэт санаж шамдан суралцахгүй бол хэмээн хичээнгүйлэн зүтгэх хүн байдаг. Гэвч зөвхөн ийм хатуу зоримог байлаа гээд бурханы үйлийг удаан үргэлжлүүлэн хийж чадахгүй. Хатуу итгэл үнэмшил болон хичээл зүтгэл мэдээж чухал ч, зөвхөн тийм байх юм бол нэг л хатуу, хөшүүн сүсэг бишрэл болж хувирна. Иймээс яахын аргагүй онгоцны далавчны жишээ шиг хатуу зоримог ба уян зөөлөн хоёрыг хоёуланг нь хослуулах нь чухал.

Хатуу зоримог сэтгэлээр хандаснаар өөрийн чадал хэр болохыг мэдэж, дутагдалтай талаа ч ойлгож ирнэ. Улмаар даруу төлөв, уян зөөлөн болж ирдэг юм.

Хатуу зоримог ба уян зөөлөн сэтгэл нь хоорондоо зөрчилдөх юм шиг санагдах боловч үнэндээ бол тийм биш ажээ.

“Kaisozuikan 6” (Kosei Publishing Co.) pp. 220□221

Талархсан сэтгэлээ гүнзгийрүүлэх нь

“Талархал нь аз жаргалыг авчирдаг.” Энэ үгийг их сонсдог ч, энэ үг нь Жинхэнэ үнэн өөрөө юм. Шагжамүни будда Шүтэн барилдлагын хуулийг гэгээрсэн. Үүнийг хүн дээр аваад үзвэл, бид дэлхий дээр оршин буй маш олон зүйлийн ачаар амьд явдаг гэсэн үг. Тэрхүү бодит үнэнийг ухаарснаар талархах сэтгэл аяндаа гарч ирдэг. Үргэлж талархаж амьдарснаар амар амгалан, аз жаргалыг олж авдаг. Яагаад гэвэл энэ нь ертөнцийн хуулийн дагуу амьдарч байна гэсэн үг болохоор юм.

Талархах сэтгэлээ гүнзгийрүүлэхийн тулд талархах үйлийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэцүү байх нь ойлгомжтой ч, хичээл зүтгэл хэрэгтэй. Байгаль ертөнцийн хишиг, өөрийн амь бие, гэр бүл, дээр нь бүхий л учралд талархах хэрэгтэй. Бусдын ачийг олж харж, түүнийгээ үгээр илэрхийлэх, өдрийн тэмдэглэлдээ бичих. Ийнхүү талархах сэтгэлээ өнгөлөн зүлгэж, талархах зуршлыг бий болгосноор аз жаргалтай болдог ажээ.

Олон Улсын Хэлтсийн дарга
Мизүтани Шооко

SHAN ZAI

Buddha's Wisdom Changes Your Life

Санал хүсэлт

“Shanzai” сэтгүүл та бүхний санал хүсэлтийг хүлээн авч байна.

Материал нийтлүүлэх, буддизмын тухай мэдмээр байгаа зүйл, ямар нэгэн асуудал зэргийн талаарх зөвөлгөө болон сэтгүүлийн талаарх санал хүсэлтийг бид баяртайгаар хүлээн авах болно.

Холбоо барих хаяг энэ хуудасны доор хэвлэгдсэн байгаа. Та бүхнийг олон сайхан санал, хүсэлт илгээнэ гэдэгт найдаж байна.

Рисшо Косей Кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон Хамтран үндэслэгч Наганума Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын сургаалыг гол нөмлодөө болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулах гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашны бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар барин, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Vol. 87 (December 2012)

【Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс, Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp
 Ахлах редактор: Мизүтани Шооко, Редактор: Накамура Эцүко, Орчуулсан: Ш.Жаргалмаа, Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг, М.Алимаа
 Хэвлэлийн баг: Ёшида Кэй-ичиро, Мацүока Шихо, Мизүмо Кацүтоши, Күдө Юкино, Это Маюми, Сүзүки Саюри, Канао Эрико, Макино Эми, Ногава Юриэ, Накаяма Ёшихиро

- Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол зэрэг 11 улсын хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна.
- Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.
- Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2012

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: rkssf@sbcglobal.net http://www.rkina.org/sanfrancisco.html

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.
http://www.buddhistlearningcenter.com/

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 Race Street, Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjehng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong,
Special Administrative Region of the People's Republic of China
Tel: 852-2-369-1836 *Fax:* 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar,
Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Castello-2229 30122-Venezia Ve Italy

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

Rissho Kosei-kai of Sydney

International Buddhist Congregation (IBC)

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: iberk@kosei-kai.or.jp <http://www.ibrk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House No.467, Road No-8 (East), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel & Fax: 94-11-2826367

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division

Delhi Dharma Center

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China